

Захирлын 2014 оны 05 дугаар сарын 02-ны
өдрийн 4/7/19 дугаар тушаалын хавсралт

УХД0072 9104399

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ОРОЙ, ЭЧНЭЭ ХӨТӨЛБӨРТ 2014 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт зарим мэргэжлээр бакалаврын зэрэгтэй иргэнийг элсүүлэхэд БШУ-ны сайдын 2005/422, 2006/483 тоот тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх үлгэрчилсэн журам” болон энэхүү журмыг баримтална.
- 1.2. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.
- 1.3. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “МУИС-ийн бүртгэлийн систем” гэнэ. Элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.
- 1.4. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.
- 1.5. Энэхүү журам болон нэмэлт мэдээллийг <http://burtgel.num.edu.mn/> цахим хуудсанд байрлуулна.
- 1.6. Элсэлтийн комиссын хаяг, хөтөлбөр, элсэх болзол хангасан элсэгчийг бүртгэх хугацаа, бусад мэдээллийг МУИС-ийн төв байрны электрон самбар болон МУИС-ийн бүртгэлийн систем, www.num.edu.mn цахим хуудсанд байрлуулна.
- 1.7. Энэхүү журмаар зохицуулагдахгүй асуудал гарвал МУИС-ийн Захирлын тушаалаар байгуулсан Элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

2. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

- 2.1. МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт (хавсралтыг үзнэ үү) бакалаврын зэрэгтэй иргэнийг элсүүлэх ба ерөнхий шалгалт (ЕШ) өгсөн байхыг шаардахгүй.
- 2.2. Хавсралтад зааснаас бусад чиглэлээр хоёр дахь бакалаврын боловсрол эзэмших хүсэлтэй иргэн “МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2014 онд Улаанбаатар хотоос оюутан элсүүлэх түр журам”-ын дагуу элсэлтийн ЕШ өгч, элсэх болзол хангаж элсэнэ. Элссэний дараа өмнө нь бакалаврын зэрэг эзэмшихдээ амжилттай судалсан хичээлээсээ 60 хүртэл багц цагийг шилжүүлэн тооцуулж болно.
- 2.3. Бүртгүүлэгч бүртгэлтэй холбоотой төлбөр тооцоог цахим хэлбэрээр хийнэ.
- 2.4. Бүртгүүлэгч нь МУИС-ийн бүртгэлийн системд бүртгүүлэхдээ өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг заавал бичнэ.

3. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

- 3.1. Элсэлтийн бүртгэлийг зөвхөн цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> бүртгэлийн системээр явуулна.
- 3.2. Элсэлтийн бүртгэл дараах өдрүүдэд явагдана. Үүнд:
 - Эрх зүйн эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 2014 оны 2-р сарын 17-наас 3-р сарын 21
 - Бусад (эрх зүйгээс бусад) эчнээ хөтөлбөрийн бүртгэл: 2014 оны 9-р сарын 1-21
 - Оройн хөтөлбөрүүдийн бүртгэл: 2014 оны 6-р сарын 16-наас 8-р сарын 20
- 3.3. Элсэлтийн тухай товч мэдээллийг бүртгэл эхлэхээс нэгээс доошгүй сарын өмнө олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж, МУИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулиудын цахим хуудас, мөн <http://burtgel.num.edu.mn> бүртгэлийн системд байршуулна.
- 3.4. Элсэгч МУИС-ийн бүртгэлийн системд хувийн мэдээлэл болон системд нэвтрэх мэдээллээ (цахим шуудангийн хаяг, нэвтрэх үг) оруулснаар элсэх хүсэлтээ гаргана.
- 3.5. Бүртгүүлэхдээ бүртгэлийн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтуудын эх хувийг сканнердаж цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:
 - Өмнө нь эзэмшсэн бакалаврын боловсролын диплом, түүний хавсралт
 - Иргэний үнэмлэх, эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг
 - Цээж зураг (Зургийн шаардлагыг бүртгэлийн системээс үзнэ үү)
- 3.6. Банкны цахим төлбөрийн системээр бүртгэл, шалгалтын хураамжийг төлнө (Голомт банк, Төрийн банк, Хас банк, Хадгаламж банк, Капитрон банкны төгрөгийн цахим гүйлгээ хийдэг, өөрийн эзэмшдэг эсвэл өөр эзэмшигчийн (эзэмшигчийн зөвшөөрлөөр) картаар төлбөр хийх боломжтой. Мөн Худалдаа хөгжлийн банк, ХААН банкнаас бусад банкны олон улсын эрхтэй картаар төлбөр хийж болно).
- 3.7. Элсэлтийн бүртгэл, шалгалтын хураамж нийлээд 10000₮ байна.
- 3.8. Бүртгүүлэхийг хүссэн хөтөлбөрийг сонгосон үед төлбөл зохих төлбөрийн хэмжээ гарах бөгөөд уг мэдээлэлтэй танилцаж, төлбөрийг цахим хэлбэрээр хийнэ.


4. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

- 4.1. Бүртгүүлэгч нь элсэхийг хүссэн хөтөлбөрт шаардлагатай хичээлээр зохих шалгалтыг өгнө. Шалгалт өгөх хичээлийн нэрсийг хавсралтад заав.
- 4.2. Шалгалт авах өдөр, цагийг элсэлтийн бүртгэл эхлэхэд <http://burtgel.num.edu.mn> бүртгэлийн системд байршуулсан байна.
- 4.3. Шалгалтанд авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авбал МУИС-д элсэх болзол хангасан гэж үзнэ. Шалгалтанд авсан нийт оноог дараах байдлаар тодорхойно. Үүнд:
 - Тухайн хөтөлбөрийн хувьд нэг шалгалт авсан бол уг шалгалтанд авсан оноо;
 - Тухайн хөтөлбөрийн хувьд хоёр шалгалт авах бол хоёр шалгалтын оноог 70:30 харьцаагаар тооцно. Өөрөөр хэлбэл, I шалгалтад авсан оноог 0.7-оор, II шалгалтад авсан оноог 0.3-аар үржүүлж нэмнэ.

5. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

- 5.1. Шалгуулагчдыг шалгалтанд авсан нийт оноогоор (4.3-т заасан аргачлалаар тодорхойлж) нь жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.


- 5.2. Хяналтын тоонд багтсан эсэхийг шалгалт дууссаны дараа шалгуулагчид ажлын хоёр өдөрт багтаан МУИС-ийн бүртгэлийн системээр мэдэгдэнэ.
- 5.3. Хяналтын тоонд багтсан элсэгч элсэх эрх авахдаа дараах материалыг бүрдүүлнэ.
Үүнд:
- а. Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг, хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрэнд) хамт
 - б. Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, хавсралтын хамт
 - в. Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхний шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сард авахуулсан)
- Эдгээр материалыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.
- 5.4. Элсэх эрх олгох үед бүртгэлийн мэдээллийг эх бичиг баримтуудтай нь тулгаж баталгаажуулна.



6 БУСАД

- 6.1. Элсэгч хуваарь буцаах тохиолдолд нэг багц цагийн үнэлгээний хэмжээний төлбөр төлнө.
- 6.2. Нэг хөтөлбөрөөс нөгөө хөтөлбөрт шилжүүлэн элсүүлэхгүй ба хуваарийг бусдад шилжүүлэхийг хориглоно.
- 6.3. Элсэгчдийг элсэн суралцуулах тухай тушаал гарсны дараа шинээр элссэн оюутан нь МУИС-ийн мэдээллийн системийг ашиглах хэрэглэгчийн нэр, нууц үгийг цахим шуудангаар хүлээн авна. Элсэгчдийг бүртгэх хугацааг хуваарь сонгох үед зарлана.
- 6.4. Тухайн хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийн хураамжийн 70 хувийг тэрхүү хөтөлбөр харьяалагддаг бүрэлдэхүүн сургууль элсэлтийн маркетингийг хийх, бүртгэл, шалгалт, хуваарь сонголтыг зохион байгуулахад зарцуулна. Үлдсэн 30 хувийг МУИС-ийн захиргаа орой, эчнээ хөтөлбөрүүдийн элсэлтийн нэгдсэн маркетингийг хийх, системийг боловсронгуй болгох болон бусад шаардлагатай үйл ажиллагаанд зориулна.
- 6.5. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн хүнийг МУИС-д элсүүлэхгүй, элссэн тохиолдолд хасна.
- 6.6. Элсэлтийг цахим хэлбэрээр явуулахад зориулсан цахим хуудас нь бүтэн жилийн турш тогтмол ажиллагаатай байж, элсэлтийн талаарх мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.
- 6.7. Цахим бүртгэл явагдаж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг утас, мессенжер болон и-мэйлээр зохион байгуулна.

МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт 2014 онд оюутан элсүүлэх хөтөлбөр, авах шалгалт, нийт оноонд эзлэх харьцаа



Бүрэлдэхүүн сургууль	Хөтөлбөр		Элсэлтийн шалгалт	
			I - 70%	II – 30%
Шинжлэх ухааны сургууль	Орой	Геологи	Математик	Газар зүй
		Англи хэлний багш	Англи хэл	
	Эчнээ	Эдийн засаг	Математик	
		Сэтгүүл зүй	Монгол хэл	
		Улс төр судлал	Нийгмийн тухай мэдлэг	
Бизнесийн сургууль	Орой	Нягтлан бодох бүртгэл Санхүү, банк Маркетинг Худалдаа Аялал жуулчлал Зочлох үйлчилгээ	Математик	
	Эчнээ	Нягтлан бодох бүртгэл Худалдаа		
Хууль зүйн сургууль	Орой	Эрх зүй	Эрх зүйн ерөнхий мэдлэг	
	Эчнээ		Үндсэн хууль /1992 он/	